



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/144

Арвайхээр

Хөрөнгө шийдвэрлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолын “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 3.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагаас ирсэн санал, хөрөнгийн үнэлгээний Мастер үнэлгээ ХХК-ын үнэлгээний тайлан дүгнэлтийг үндэслэн Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн хуучин барилгыг 1473 м.кв газар эзэмших эрхийн (барилгад хамаарах газар нь 624 м.кв, зогсоолын газар нь 849 м.кв, зогсоолын газрын хамт) хамт дуудлага худалдаагаар худалдсугай.

2. Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн худалдах доод үнийг 23,000,000 (хорин гурван сая) төгрөгөөр тогтоосугай.

3. Хөрөнгийн дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, орлогыг “Орон нутгийн өмч худалдсаны орлого” дансанд төвлөрүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Балданням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100312